

**ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН  
2020 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН,  
ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН САНХҮҮГИЙН  
ТАЙЛАНГИЙН АУДИТ**

## Агуулга

|                                                                                    |    |
|------------------------------------------------------------------------------------|----|
| 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....                          | 4  |
| 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....                                   | 4  |
| 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....                                | 4  |
| 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....                     | 5  |
| 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....                                     | 5  |
| 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....                                 | 6  |
| 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....                           | 7  |
| 3. Аудитын тайлан.....                                                             | 8  |
| 3.1 Ерөнхий зүйл .....                                                             | 8  |
| 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....                                | 8  |
| 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, түүний хүлээн зөвшөөрөхүйц байдал ..... | 9  |
| 3.4 Материаллаг байдал.....                                                        | 9  |
| 3.5 Санхүүгийн тайлангийн үзүүлэлт .....                                           | 9  |
| 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв .....                               | 10 |
| 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг .....                          | 11 |
| 3.8 Аудитын гол асуудал.....                                                       | 12 |
| 3.9 Шилэн дансны мэдээлэл .....                                                    | 12 |
| 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....                                               | 12 |
| 3.11 Хойших үйл явдал ба дараагийн аудитаар анхаарах асуудал .....                 | 13 |
| 3.12. Аудитын илрүүлэлт .....                                                      | 13 |
| Залруулсан алдаа.....                                                              | 13 |
| Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил .....                    | 13 |
| Аудитын зөвлөмж.....                                                               | 13 |
| 4. Менежментийн захидал.....                                                       | 14 |
| 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....                                  | 15 |

**Товчилсон үгийн жагсаалт**

|          |                                                             |
|----------|-------------------------------------------------------------|
| АДБОУС   | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт               |
| АОУС     | Аудитын Олон Улсын Стандарт                                 |
| НБББББ   | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг              |
| ТӨБЗГ    | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар                   |
| ТЕЗ      | Төсвийн ерөнхийлөн захирагч                                 |
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| САГ      | Санхүүгийн аудитын газар                                    |
| СТА      | Санхүүгийн тайлангийн аудит                                 |



**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ АУДИТОР**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас: 26-04-37, Факс: 51-26-42-30  
E-mail: info@audit.gov.mn

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН  
ДАРГА Б.БААТАРЗОРИГ ТАНАА

2021.04.26 № 1314

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Аудитын санал дүгнэлт

### Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Төрийн албаны зөвлөлийн даргын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төрийн албаны зөвлөлийн даргын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.



Д.ЗАНДАНБАТ

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2020 оны 12 дугаар сарын 31-нээр дуусвар болсон тайлан

/мянган төгрөг/

| Код:     | Тайлангийн үзүүлэлт                                                   | Эхний<br>үлдэгдэл | Эцсийн<br>үлдэгдэл |
|----------|-----------------------------------------------------------------------|-------------------|--------------------|
| 1        | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН                                               | 16,717.7          | 121,090.5          |
| 31       | МӨНГӨН ХӨРӨНГӨ                                                        | 0.0               | 61,785.1           |
| 33       | АВЛАГА                                                                | 0.0               | 475.9              |
| 35       | БАРАА МАТЕРИАЛ                                                        | 16,717.7          | 58,829.5           |
| 2        | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН                                           | 415,897.9         | 1,410,649.8        |
| 39       | ҮНДСЭН ХӨРӨНГӨ                                                        | 415,897.9         | 1,410,649.8        |
| 39200    | Биет хөрөнгө                                                          | 296,181.3         | 1,293,899.3        |
| 39300    | Биет бус хөрөнгө                                                      | 119,716.6         | 116,750.4          |
| <b>3</b> | <b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>                                    | <b>432,615.6</b>  | <b>1,531,740.2</b> |
| 4        | НИЙТ ӨР ТӨЛБӨР                                                        | 0.0               | 3,202.6            |
| 41       | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР                                             | 0.0               | 3,202.6            |
| 41300    | Өглөг                                                                 | 0.0               | 3,202.6            |
| 5        | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН                                              | 432,615.6         | 1,528,537.6        |
| 51       | Засгийн газрын хувь оролцоо                                           | 432,615.6         | 1,528,537.6        |
| 51100    | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 434,739.6         | 434,739.6          |
| 51200    | Хуримтлагдсан үр дүн                                                  | (2,993.5)         | 1,092,928.5        |
| 51300    | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү                                      | 869.5             | 869.5              |
| <b>6</b> | <b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>                    | <b>432,615.6</b>  | <b>1,531,740.2</b> |

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2020 оны 12 дугаар сарын 31-нээр дуусвар болсон тайлан

/мянган төгрөг/

| Код:       | Тайлангийн үзүүлэлт                                      | Эхний<br>үлдэгдэл  | Эцсийн<br>үлдэгдэл |
|------------|----------------------------------------------------------|--------------------|--------------------|
| <b>I</b>   | <b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>                   | <b>1,413,503.9</b> | <b>3,990,268.6</b> |
| 12         | ТАТВАРЫН БУС ОРЛОГО                                      | 91,286.5           | 62,835.1           |
| 120        | Нийтлэг татварын бус орлого                              | 91,286.5           | 62,835.1           |
| 13         | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО                            | 1,322,217.4        | 3,927,433.5        |
| <b>II</b>  | <b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>                       | <b>1,269,125.9</b> | <b>2,894,346.6</b> |
| 21         | УРСГАЛ ЗАРДАЛ                                            | 1,269,125.9        | 2,894,346.6        |
| 210        | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ                          | 1,151,610.1        | 2,344,609.0        |
| 2101       | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил                        | 627,664.3          | 940,147.9          |
| 2102       | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл           | 79,378.9           | 126,366.6          |
| 2103       | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал                | 22,213.5           | 22,050.5           |
| 2104       | Хангамж, бараа материалын зардал                         | 87,157.2           | 117,729.9          |
| 2106       | Эд хогшил, урсгал засварын зардал                        | 0.0                | 282,283.6          |
| 2107       | Томилолт, зочны зардал                                   | 14,398.6           | 758.6              |
| 2108       | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 192,392.1          | 545,516.9          |
| 2109       | Бараа үйлчилгээний бусад зардал                          | 128,405.4          | 309,755.0          |
| 213        | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ                                         | 117,515.8          | 549,737.6          |
| <b>III</b> | <b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)</b>             | <b>144,378.1</b>   | <b>1,095,922.0</b> |
| <b>VI</b>  | <b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)</b>   | <b>144,378.1</b>   | <b>1,095,922.0</b> |

## 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2020 оны 12 дугаар сарын 31-нээр дуусвар болсон тайлан

/мянган төгрөг/

| Код: | Тайлангийн үзүүлэлт                        | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн | Цөөнхийн хувь оролцоо | Нийт цэвэр хөрөнгө/өмч |
|------|--------------------------------------------|----------------------------------------|-----------------------|------------------------|
| 1    | <b>2018 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл</b> | <b>288,237.6</b>                       | <b>0.0</b>            | <b>288,237.6</b>       |
| 3    | Дахин илэрхийлсэн үлдэгдэл                 | 288,237.6                              | 0.0                   | 288,237.6              |
| 9    | Тайлант үеийн үр дүн                       | 144,378.1                              | 0.0                   | 144,378.1              |
| 10   | <b>2019 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл</b> | <b>432,615.6</b>                       | <b>0.0</b>            | <b>432,615.6</b>       |
| 13   | Дахин илэрхийлсэн үлдэгдэл                 | 432,615.6                              | 0.0                   | 432,615.6              |
| 19   | Тайлант үеийн үр дүн                       | 1,095,922.0                            | 0.0                   | 1,095,922.0            |
| 20   | <b>2020 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл</b> | <b>1,528,537.6</b>                     | <b>0.0</b>            | <b>1,528,537.6</b>     |

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2020 оны 12 дугаар сарын 31-нээр дуусвар болсон тайлан

/мянган төгрөг/

| Код: | Тайлангийн үзүүлэлт                                          | Эхний үлдэгдэл     | Эцсийн үлдэгдэл    |
|------|--------------------------------------------------------------|--------------------|--------------------|
| I    | <b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>                | <b>1,413,503.9</b> | <b>3,686,666.1</b> |
| 12   | ТАТВАРЫН БУС ОРЛОГО                                          | 346.5              | 62,103.3           |
| 120  | Нийтлэг татварын бус орлого                                  | 346.5              | 62,103.3           |
| 13   | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО                                | 1,413,157.4        | 3,624,562.8        |
| II   | <b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>                     | <b>1,413,503.9</b> | <b>2,668,575.0</b> |
| 21   | УРСГАЛ ЗАРДАЛ                                                | 1,413,503.9        | 2,668,575.0        |
| 210  | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ                              | 1,295,988.2        | 2,118,837.4        |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил                            | 627,664.3          | 939,390.3          |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл               | 79,378.9           | 126,842.5          |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал                    | 22,213.5           | 26,773.2           |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал                             | 74,189.4           | 134,615.5          |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал                            | 122,207.0          | 286,182.2          |
| 2107 | Томилолт, зочны зардал                                       | 14,398.6           | 758.6              |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж     | 315,036.8          | 549,340.1          |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал                              | 40,899.7           | 54,935.1           |
| 213  | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ                                             | 117,515.8          | 549,737.6          |
| III  | <b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)</b>   | -                  | 1,018,091.1        |
| V    | <b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)</b>             | -                  | 956,306.0          |
| 22   | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ                                             | -                  | 956,306.0          |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр                                          | -                  | 956,306.0          |
| VI   | <b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)</b> | -                  | (956,306.0)        |
| VIII | <b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)</b>     | -                  | 61,785.1           |
| 101  | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл             | -                  | 0                  |
| 10   | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл            | -                  | 61,785.1           |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

| /төгрөгөөр/ |                                                                      |                  |                  |                |       |
|-------------|----------------------------------------------------------------------|------------------|------------------|----------------|-------|
| Код         | Үзүүлэлт                                                             | Төлөвлөгөө       | Гүйцэтгэл        | Зөрүү          | Хувь  |
| II          | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН                                    | 3,492,935,800.00 | 2,940,208,692.82 | 552,727,107.18 | 84.2  |
| 21          | УРСГАЛ ЗАРДАЛ                                                        | 3,492,935,800.00 | 2,940,208,692.82 | 552,727,107.18 | 84.2  |
| 210         | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ                                      | 3,441,248,800.00 | 2,920,594,793.82 | 520,654,006.18 | 84.9  |
| 2101        | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил                                    | 1,354,688,200.00 | 939,390,266.12   | 415,297,933.88 | 69.3  |
| 210101      | Үндсэн цалин                                                         | 732,653,600.00   | 605,940,500.23   | 126,713,099.77 | 82.7  |
| 210102      | Нэмэгдэл                                                             | 472,850,600.00   | 245,057,400.19   | 227,793,199.81 | 51.8  |
| 210103      | Унаа хоолны хөнгөлөлт                                                | 149,184,000.00   | 88,392,365.70    | 60,791,634.30  | 59.3  |
| 2102        | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл                       | 190,307,800.00   | 126,842,514.86   | 63,465,285.14  | 66.7  |
| 210201      | Тэтгэврийн даатгал                                                   | 133,920,400.00   | 99,017,485.95    | 34,902,914.05  | 73.9  |
| 210202      | Тэтгэмжийн даатгал                                                   | 14,096,800.00    | 16,294,578.55    | (2,197,778.55) | 115.6 |
| 210203      | ҮОМШӨ-ний даатгал                                                    | 11,277,500.00    | 3,128,713.00     | 8,148,787.00   | 27.7  |
| 210204      | Ажилгүйдлийн даатгал                                                 | 2,819,300.00     | 763,794.33       | 2,055,505.67   | 27.1  |
| 210205      | Эрүүл мэндийн даатгал                                                | 28,193,800.00    | 7,637,943.03     | 20,555,856.97  | 27.1  |
| 2103        | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал                            | 27,807,100.00    | 26,773,240.00    | 1,033,860.00   | 96.3  |
| 210304      | Байрны түрээс                                                        | 27,807,100.00    | 26,773,240.00    | 1,033,860.00   | 96.3  |
| 2104        | Хангамж, бараа материалын зардал                                     | 147,379,700.00   | 132,501,808.42   | 14,877,891.58  | 89.9  |
| 210401      | Бичиг хэрэг                                                          | 29,259,300.00    | 25,927,175.00    | 3,332,125.00   | 88.6  |
| 210402      | Тээвэр, шатахуун                                                     | 61,826,600.00    | 57,817,999.00    | 4,008,601.00   | 93.5  |
| 210403      | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр                                   | 11,690,800.00    | 11,684,084.42    | 6,715.58       | 99.9  |
| 210404      | Ном, хэвлэл                                                          | 4,350,000.00     | 4,350,000.00     | -              | 100.0 |
| 210406      | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс                          | 40,253,000.00    | 32,722,550.00    | 7,530,450.00   | 81.3  |
| 2106        | Эд хогшил, урсгал засварын зардал                                    | 634,854,200.00   | 612,668,485.00   | 22,185,715.00  | 96.5  |
| 210601      | Багаж, техник, хэрэгсэл                                              | 336,943,300.00   | 333,384,910.00   | 3,558,390.00   | 98.9  |
| 210604      | Урсгал засвар                                                        | 297,910,900.00   | 279,283,575.00   | 18,627,325.00  | 93.7  |
| 2107        | Томилолт, зочны зардал                                               | 758,600.00       | 758,600.00       | -              | 100.0 |
| 210702      | Дотоод албан томилолт                                                | 758,600.00       | 758,600.00       | -              | 100.0 |
| 2108        | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж             | 1,039,366,100.00 | 1,038,144,823.42 | 1,221,276.58   | 99.9  |
| 210801      | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 158,390,900.00   | 157,468,100.00   | 922,800.00     | 99.4  |
| 210803      | Даатгалын үйлчилгээ                                                  | 130,000.00       | 0                | 130,000.00     | -     |
| 210804      | Тээврийн хэрэгслийн татвар                                           | 277,200.00       | 175,500.00       | 101,700.00     | 63.3  |
| 210805      | Тээврийн хэрэгслийн оношилгоо                                        | 30,000.00        | 0                | 30,000.00      | -     |
| 210806      | Мэдээлэл, технологийн үйлчилгээ                                      | 880,538,000.00   | 880,501,223.42   | 36,776.58      | 100.0 |
| 2109        | Бараа үйлчилгээний бусад зардал                                      | 46,087,100.00    | 43,515,056.00    | 2,572,044.00   | 94.4  |

|        |                                                     |                  |                  |                |      |
|--------|-----------------------------------------------------|------------------|------------------|----------------|------|
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал                     | 1,393,000.00     | 0                | 1,393,000.00   | -    |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх                   | 44,694,100.00    | 43,515,056.00    | 1,179,044.00   | 97.4 |
| 213    | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ                                    | 51,687,000.00    | 19,613,899.00    | 32,073,101.00  | 37.9 |
| 2132   | Бусад урсгал шилжүүлэг                              | 51,687,000.00    | 19,613,899.00    | 32,073,101.00  | 37.9 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 30,192,000.00    | 0                | 30,192,000.00  | -    |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал             | 21,495,000.00    | 19,613,899.00    | 1,881,101.00   | 91.2 |
| III    | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР                      | 3,492,935,800.00 | 2,940,526,892.82 | 552,408,907.18 | 84.2 |
| 31     | УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ                             | 3,492,935,800.00 | 2,940,208,692.82 | 552,727,107.18 | 84.2 |
| 310001 | Улсын төсвөөс санхүүжих                             | 3,492,935,800.00 | 2,940,208,692.82 | 552,727,107.18 | 84.2 |
| 35     | ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС               | 0                | 318,200.00       | (318,200.00)   |      |
| 350001 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих           | 0                | 318,200.00       | (318,200.00)   |      |
| 61     | БАЙГУУЛЛАГЫН ТОО                                    | 1                | 1                | -              | 100  |
| 62     | АЖИЛЛАГСДЫН ТОО                                     | 61               | 61               | -              | 100  |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

|        |                                                                              | /төгрөгөөр/    |
|--------|------------------------------------------------------------------------------|----------------|
| Код    | Үзүүлэлт                                                                     | Гүйцэтгэл      |
| II     | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН                                            | 163,020,026.00 |
| 21     | УРСГАЛ ЗАРДАЛ                                                                | 163,020,026.00 |
| 210    | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ                                              | 154,548,650.00 |
| 2104   | Хангамж, бараа материалын зардал                                             | 2,113,650.00   |
| 210401 | Бичиг хэрэг                                                                  | 390,000.00     |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр                                           | 1,578,650.00   |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс                                  | 145,000.00     |
| 2106   | Эд хогшил, урсгал засварын зардал                                            | 3,000,000.00   |
| 210604 | Урсгал засвар                                                                | 3,000,000.00   |
| 2108   | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж                     | 138,015,000.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж         | 134,652,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ                                              | 3,363,000.00   |
| 2109   | Бараа үйлчилгээний бусад зардал                                              | 11,420,000.00  |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал                                              | 6,500,000.00   |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх                                            | 4,920,000.00   |
| 213    | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ                                                             | 8,471,376.00   |
| 2132   | Бусад урсгал шилжүүлэг                                                       | 3,500,000.00   |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал                                      | 3,500,000.00   |
| 2133   | Олгосон санхүүжилт, шилжүүлэг                                                | 4,971,376.00   |
| 213305 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг    | 4,971,376.00   |
| I      | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР                                               | 163,020,026.00 |
| 1311   | Нэмэлт санхүүжилтийн орлого                                                  | 163,020,026.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 163,020,026.00 |

### 3. Аудитын тайлан

#### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Төрийн албаны зөвлөлийн даргын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд үндсэн хөрөнгийн данс, дотоод хяналттай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Аудитын хоёрдугаар газрын ахлах аудитор Б.Сэржмядаг, аудитор Н.Нямсүрэн нар гүйцэтгэж, чанарын хяналтыг аудитын менежер С.Нацагдорж, Аудитын дөрөвдүгээр газрын захирал, тэргүүлэх аудитор Я.Самбууням нар тус тус хэрэгжүүлсэн.

Төрийн албаны зөвлөлийн даргын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2021 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн 01/936 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

#### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Төрийн албаны зөвлөлийн эрхэм зорилго нь иргэдэд ойр, уян хатан, идэвхтэй, санаачилгатай бөгөөд цомхон, чадварлаг, үр дүнд чиглэсэн манлайлагч менежер бүхий төрийн албыг бүрдүүлэхэд оршино. Зөвлөл хуулиар олгогдсон бүрэн эрхийнхээ дагуу дараах зорилтыг хэрэгжүүлэхээр төлөвлөн ажиллаж байна.Үүнд:

- Төрийн жинхэнэ албаны ерөнхий болон тусгай шалгалтыг зохион байгуулах;
- Хяналт шалгалт, шинжилгээ, үнэлгээ хийх;
- Маргаан хянан шийдвэрлэх;
- Сургалт судалгаа зохион байгуулах, мэдээллийн нэгдсэн санг эрхлэх;
- Мэргэшил, арга зүйн зөвлөгөө өгөх.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт орсон дараах хуулиуд байна. Үүнд:

- Төрийн албаны тухай хууль
- Засгийн газрын 2020 оны “Төрийн жинхэнэ зарим албан тушаалын цалингийн сүлжээг тогтоох” тухай 75 дугаар тогтоол

Мөн дэлхий нийтийг хамарсан Ковид-19 цар тахлын улмаас дараах 3Г-ын тогтоолууд гарсан байна. Үүнд:

- Төсвийн ерөнхийлөн захирагч нарт зохицуулалтын эрх олгох тухай 187;
- Бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан эдийн засгийг дэмжих чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай 78 ;
- Бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан эдийн засгийг дэмжих чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай 114;
- Ковид-19 цар тахлын үед төсвийн зохицуулалт хийх зарим арга хэмжээний тухай 168;
- Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан эдийн засгийг дэмжих чиглэлээр авах зарим арга хэмжээний 183 дугаар тогтоолууд.

Төрийн албаны зөвлөл нь Хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газаргүй бөгөөд тайлант онд дотоод хяналт шалгалт хийгээгүй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг 2014 оноос хойш шинэчлэгдээгүй бөгөөд тайлант онд шинэчлэн боловсруулахаар гэрээ байгуулан ажиллаж, 2021 онд хэвлэгдэхээр болжээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, түүний хүлээн зөвшөөрөхүйц байдал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн аудитын зорилго оршино.

Төрийн албаны зөвлөлийн даргын 2020 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлсөн, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 2,715.8 сая төгрөгөөс 1.0 хувиар буюу 27.2 сая төгрөгөөр тооцсон.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлыг аудитаар залруулсан санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 2,894.3 сая төгрөгөөс 1.0 хувиар буюу 28.9 сая төгрөгөөр дахин тооцлоо.

### 3.5 Санхүүгийн тайлангийн үзүүлэлт

Төрийн албаны зөвлөлийн тайлант оны санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1,099.1 сая төгрөгөөр өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үндсэн хөрөнгө, засгийн газрын оролцоо данс байна.

Хүснэгт-1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/сая төгрөг/

| Үзүүлэлт                            | Эхний<br>үлдэгдэл | Эцсийн<br>үлдэгдэл | Өөрчлөлт       |
|-------------------------------------|-------------------|--------------------|----------------|
| Б                                   | 1                 | 2                  | 3=2-1          |
| Мөнгөн хөрөнгө                      | -                 | 61.8               | 61.8           |
| Авлага                              | -                 | 0.5                | 0.5            |
| Бараа материал                      | 16.7              | 58.8               | 42.1           |
| Үндсэн хөрөнгө                      | 415.9             | 1,410.6            | 994.8          |
| Нийт хөрөнгийн дүн                  | <b>432.6</b>      | <b>1,531.7</b>     | <b>1,099.1</b> |
| Нийт өр төлбөр                      | -                 | 3.2                | 3.2            |
| Засгийн газрын хувь оролцоо         | 432.6             | 1,528.5            | 1,095.9        |
| Өр төлбөр, цэвэр хөрөнгө өмчийн дүн | <b>432.6</b>      | <b>1,531.7</b>     | <b>1,099.1</b> |

Эх сурвалж: ТАЗ-ийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 61.8 сая төгрөгөөр өссөн нь ахмадын сангийн үлдэгдэл 43.5 сая, барьцаа хөрөнгийн дансны үлдэгдэл 18.3 сая төгрөгөөр нэмэгдсэнтэй холбоотой байна.

Авлага дансны үлдэгдэл 0.5 сая төгрөгөөр өссөн нь нийгмийн даатгалын байгууллагаас авах авлага байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 58.8 сая төгрөг болж, 42.1 сая төгрөгөөр өссөн нь 25.9 сая төгрөгөөр бэлэн бүтээгдэхүүн, 26.5 сая төгрөгөөр албан ажлын хэрэгцээнд зориулан бичиг хэргийн материал худалдан авснаас голлон шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,410.6 сая төгрөг болж, 994.8 сая төгрөгөөр өссөн нь машин тоног төхөөрөмж 1,076.5 сая, тавилга эд хогшил 136.5 сая, программ хангамж 45.4 сая, нийт 1,258.5 сая төгрөгөөр нэмэгдсэн бөгөөд урсгал төсвөөс 956.3 сая, Нэгдсэн Үндэсний байгууллагын Хөгжлийн хөтөлбөрөөс хэрэгжүүлж байгаа төслийн хүрээнд хандивын 302.2 сая төгрөгөөр тус тус санхүүжигдсэн байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 3.2 сая төгрөгөөр өссөн нь “Лидер Вишн Групп” ХХК-д өгөх өглөг 2.4 сая, ажилчидтай холбоотой өглөг 0.8 сая төгрөгөөр нэмэгдсэнээс шалтгаалжээ.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,528.5 сая төгрөг болж, 1,095.9 сая төгрөгөөр өссөн нь тайлант оны нийт үр дүнгээс шалтгаалсан байна.

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 2,576.8 сая төгрөгөөр өссөн нь урсгал үйл ажиллагааны санхүүжилт 2,273.9 сая төгрөг, үнэ төлбөргүй хүлээн авсан орлого 302.9 сая төгрөгөөр өссөнтэй холбоотой байна.

Нийт зардал өмнөх оноос 1,625.2 сая төгрөгөөр өссөн нь үндсэн цалин 312.5 сая, эд хогшил, урсгал засварын зардал 282.3 сая, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр 353.1 сая төгрөгөөр өссөнөөс голлон шалтгаалсан байна.

### **3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр, нийт зарлагыг 3,604.3 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, Төсөв, санхүү эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлснийг байгууллагын саналаар баталсан байна.

Батлагдсан төсөвт 2 удаа тодотгол хийж, бараа үйлчилгээний зардлыг 110,8 сая, бусад урсгал шилжүүлгийг 0.8 сая, нийт 111,4 сая төгрөгөөр бууруулан 3,492,9 сая төгрөгөөр баталсан байна. Нийт зардлыг бууруулсан нь Дэлхий нийтийг хамарсан Ковид-19 цар тахалтай холбоотойгоор 2020 оны төсвийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хууль батлагдаж өөрчлөлт хийсэн нь нөлөөлжээ.

#### **Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 7 арга хэмжээг санхүүжүүлэхээр 3,492.9 сая төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 3,461.5 сая төгрөгийн санхүүжилт авч, бусад орлого 0.3 сая төгрөг, нийт 3,461.8 сая төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 2,940.2 сая төгрөг зарцуулж, 521.6 сая төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,940.2 сая төгрөг буюу 84.2 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардал 478.0 сая /цалин хөлс болон нэмэгдэл, урамшуулал 415.3 сая, эд хогшил, урсгал засварын зардал 22.2 сая, хангамж бараа материалын зардал 14.9 сая, тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмжийг 30.2 сая төгрөг/, гэрээгээр гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээний зардал 63.6 сая, ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшууллын зардал 11.0 сая төгрөгөөр дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт-2 Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/сая төгрөг/

| Д/Д | Хөтөлбөр, арга хэмжээний |                                                  | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь  |
|-----|--------------------------|--------------------------------------------------|------------|-----------|-------|-------|
|     | Код                      | Нэр                                              |            |           |       |       |
| 1   | 70401                    | Төрийн албаны ерөнхий удирдлага                  | 3,492.9    | 2,940.5   | 552.4 | 84.2  |
| 1.1 | 80101                    | Үндсэн үйл ажиллагааны зардал                    | 3,226.0    | 2,748.0   | 478.0 | 85.2  |
| 1.2 | 80802                    | Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшууллын зардал | 30.6       | 19.6      | 11.0  | 64.1  |
| 1.3 | 80103                    | Гэрээгээр гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээний зардал | 109.0      | 45.4      | 63.6  | 41.7  |
| 1.4 | 80205                    | Мэдээлэл, сурталчилгааны зардал                  | 0.5        | 0.0       | 0.5   | 0.0   |
| 1.5 | 80224                    | Зөвлөл, хороо, комиссын гишүүдийн ажлын хөлс     | 4.3        | 3.9       | 0.4   | 90.7  |
| 1.6 | 80226                    | Байр ашиглалтын үйлчилгээний зардал              | 121.1      | 123.6     | (2.5) | 102.1 |
| 1.7 | 80305                    | Биеийн тамирын уралдаан, тэмцээний зардал        | 1.4        | 0.0       | 1.4   | 0.    |

Эх сурвалж: ТАЗ-ийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

### Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд төрийн албаны ерөнхий шалгалтын хураамжийн орлого 163.0 сая төгрөг бүрдүүлжээ. Үүнээс бусдаар гүйцэтгүүлсэн, бусад нийтлэг ажил үйлчилгээний зардалд 134.7 сая, бараа үйлчилгээний бусад зардалд 23.3 сая төгрөгийг зарцуулж, 5.0 сая төгрөгийн үлдэгдлийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Төрийн албаны зөвлөл нь батлагдсан төсвийг хуульд нийцүүлэн зориулалтын дагуу үр ашигтай зарцуулж, төсвийн урсгал зардлын хүрээнд худалдан авах ажиллагааг хэрэгжүүлж, байгууллагын үйл ажиллагааны чадавх сайжирсан байна.

Засгийн газрын 2020 оны 163 дугаар тогтоолыг хэрэгжүүлснээр нөөцийн системд нэмэлт хөгжүүлэлт хийж, Сангийн яамны цалингийн нэгдсэн системтэй уялдуулснаар төрийн албаны хүний нөөцийн мэдээлэлд суурилсан төрийн албаны цалингийн нэгдсэн системийг төсвийн бүх байгууллагад үе шаттайгаар нэвтрүүлэн ажилласан байна.

Энэ системийг нэвтрүүлснээр 4,355 байгууллагын 182,171 албан хаагчийн цалинг нэгдсэн системээр олгодог болж, төрийн албан хаагчид сар тутмын цалин хөлсний дэлгэрэнгүй мэдээллээ цаг алдалгүй цахим шуудангаар хүлээн авах боломж бүрджээ.

Мөн төрийн албаны шалгалтын программыг шинээр болон шинэчлэн хөгжүүлснээр төрийн албаны ерөнхий болон тусгай шалгалтуудыг цахим хэлбэрээр хөндлөнгийн оролцоо, нөлөөлөлгүй шударгаар явуулах нөхцөл хангагджээ. Төрийн албаны зөвлөл байрладаг Засгийн газрын 11 дүгээр байрны 1 давхарт 535 м2 талбайд барилгын шинэчлэл, их засварын ажил хийж, төрийн албаны сургалтын, шалгалтын, уулзалтын, албан хаагчдын зэрэг нийт 12 өрөө, тасалгаа бүхий орчин үеийн техник хэрэгсэл, тавилга тоног төхөөрөмжөөр иж бүрэн тоноглогдсон Олон үйлдэлт танхимыг ашиглалтад оруулснаар хурал, сургалт зөвлөгөөн, уулзалт, төрийн албаны шалгалтын үйл ажиллагааны жишиг орчныг бүрдүүлсэн байна.

Байгууллагын албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд дотоод удирдлагын Able программыг бүрэн нэвтрүүлж, ажиллах нөхцөлийг бодитой сайжруулснаар албан бичиг, өргөдөл гомдлын шийдвэрлэлтийг эрчимжүүлэх, төрийн байгууллагуудыг мэргэшил, арга зүйн зөвлөгөө, зөвлөмжөөр хангах үйл ажиллагааг идэвхжүүлэх, албан хаагчид ажил үүргээ шуурхай, үр дүнтэй гүйцэтгэх боломж, бололцоо дээшилсэн байна.

Ковид-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд зориулан иргэд, аж ахуйн нэгж байгууллагаас авсан хандив байхгүй байна.

### 3.8 Аудитын гол асуудал

Төрийн албаны зөвлөлийн даргын 2020 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтэд тусгагдсан 4 чиглэлийн 11 ажлаас ерөнхий болон тусгай шалгалтыг зохион байгуулсан хувь нь зорилтот түвшинд хүрээгүй байна.

Энэ нь Ковид-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх зорилгоор улс орны хэмжээнд гамшгаас хамгаалах өндөржүүлсэн болон бүх нийтийн бэлэн байдалд шилжүүлсэнтэй холбоотойгоор төрийн албаны ерөнхий шалгалтыг 1 удаа зохион байгуулсан, төрийн байгууллагуудын сул орон тоог нөхөх тусгай шалгалтын үйл ажиллагаа жилийн туршид жигд явагдаж чадаагүйтэй холбоотой байна.

Төрийн албаны шалгалтыг цахимаар сорил өгөх, сорилын ном унших зэрэг шалгалтад бэлтгэх олон талын боломжийг олгосноор ерөнхий шалгалт өгсөн иргэдийн 31.1 хувь нь тэнцэж, өмнөх оноос 2 дахин өссөн байна.

Мөн тусгай шалгалтын үйл ажиллагаа эрчимжиж, төрийн захиргааны удирдах, гүйцэтгэх болон төрийн үйлчилгээний байгууллагын төсвийн шууд захирагчийн тусгай шалгалтаар нөхсөн сул орон тоо өмнөх оноос 3.6-44.5 дахин өссөн байна.

### 3.9 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 156 мэдээллээс хугацаандаа оруулсан 152 мэдээлэл, хугацаа болоогүй 4 мэдээлэл байна.

### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн нийт 25.1 сая төгрөгийн зөрчлөөс 3.7 сая төгрөгийн төлбөрийн актын биелэлт 100 хувь, 12.1 сая төгрөгийн зөрчлийг арилгах 1 албан шаардлагын биелэлт 100 хувь, 9.3 сая төгрөгийн 3 зөвлөмжийн хэрэгжилт 86.7 хувьтай байна.

Хүснэгт-3 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт /сая төгрөг/

| Үзүүлэлт        | Өмнөх оны илрүүлэлт |             | Биелэлт  |      | Зөрүү |     |             |
|-----------------|---------------------|-------------|----------|------|-------|-----|-------------|
|                 | Тоо                 | Дүн         | Тоо      | Дүн  | Тоо   | Дүн | Хувь        |
| Акт             | 1                   | 3.7         | 1        | 3.7  | -     | -   | 100         |
| Албан шаардлага | 1                   | 12.1        | 1        | 12.1 |       | -   | 100         |
| Зөвлөмж         | 3                   | 9.3         | 3        | 9.3  |       |     | 86.7        |
| <b>Нийт дүн</b> | <b>5</b>            | <b>25.1</b> | <b>5</b> |      |       |     | <b>95.5</b> |

### **3.11 Хойших үйл явдал ба дараагийн аудитаар анхаарах асуудал**

Дэлхий нийтийг хамарсан Ковид-19 цар тахлын улмаас аудитыг цахимаар хийж байгаатай холбоотой аудит хийх цар хүрээ хязгаарлагдаж, байгууллага дээр ажиллаж нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэх, анхан шатны баримт материалуудыг бүрэн хамруулж, хөрөнгийн биет тооллого хийх, цалин хөлсний тушаал шийдвэр гэх мэт төсвийн хяналтыг бүрэн хэрэгжүүлэх нөхцөл байдал хязгаарлагдмал байсныг дараагийн тайлант хугацаанд анхаарах нь зүйтэй гэж үзлээ.

### **3.12. Аудитын илрүүлэлт**

Аудитаар нийт 1,437.8 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 1,437.8 сая төгрөгийн 3 алдааг залруулж, алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өглөө.

#### **Залруулсан алдаа**

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

- Тайлант онд Нэгдсэн Үндэсний Байгууллагаас хандиваар авсан 302.9 сая төгрөгийн хөрөнгийг санхүүгийн үр дүнгийн тайланд улсын төсвийн хөрөнгөөр авсан гэж тайлагнасан;
- Үндсэн хөрөнгийн тодруулгын тайланд төсвийн хөрөнгөөр худалдан авсан 956.3 сая төгрөгийн хөрөнгийг бусад хэсэгт бүртгэж тайлагнасан;
- Үндсэн хөрөнгийн элэгдлийн зардлыг 178.6 сая төгрөгөөр дутуу тооцож, тайлагнасныг тус тус залруулсан.

#### **Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил**

Аудитаар зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал гараагүй болно.

#### **Аудитын зөвлөмж**

Аудитаар илэрсэн алдаа, зөрчилд 2 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

#### **4. Менежментийн захидал**

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

##### **1. Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал**

**1.1.Илрүүлэлт:** Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 73 нэр төрлийн 223.0 сая төгрөгийн хөрөнгийн асуудлыг холбогдох, эрх бүхий байгууллагаар шийдвэрлүүлээгүй, хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох арга хэмжээ аваагүй байна. Энэ нь ТӨБЗГ-ын 2019 оны 271 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам” 7.1-д "Төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж, засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ" гэж заасантай нийцээгүй, санхүүгийн тайлангийн үнэлгээ ба хуваарилалт, тодруулга ба толилуулга батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

**1.2.Өгсөн зөвлөмж:** Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт хүргүүлж, шийдвэрлүүлэх.

##### **2. Дотоод хяналттай холбоотой асуудал**

**2.1.Илрүүлэлт:** Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяаны дотоод аудитын бүтцийн нэгжгүй, тайлант онд санхүүгийн болон бусад үйл ажиллагаанд дотоод хяналт, шалгалт хийгдээгүй байна. Энэ нь Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор баталсан Дотоод аудитын дүрмийн 4.1-т “Төсвийн ерөнхийлөн захирагч нь хуульд заасан чиг үүргийг хэрэгжүүлэх дотоод аудитын нэгжтэй байна” гэж заасантай нийцэхгүй байна.

**2.2.Өгсөн зөвлөмж:** Төсвийн ерөнхийлөн захирагч нь хуульд заасан чиг үүргийг хэрэгжүүлэх дотоод аудитын нэгжтэй байна гэж заасны дагуу орон тоо, хүний нөөцийн боломжид тулгуурлан хэрэгжүүлэх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 09 дүгээр сарын 30 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

|                              |                      |                                                                                                   |                     |
|------------------------------|----------------------|---------------------------------------------------------------------------------------------------|---------------------|
| Огноо:                       | Аудитын нэр:         | <b>Төрийн албаны зөвлөлийн даргын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит</b> | Аудитын код:        |
| 2021                         |                      |                                                                                                   | САГ-2021/16/СТА-ТЕЗ |
| Шалгагдсан байгууллагын нэр: | Төрийн албаны зөвлөл |                                                                                                   | сая төгрөг          |

| № | Алдаа, зөрчлийн товч утга                                                                                                              | Мөнгөн дүн | Аудитын байгууллагаа с гаргасан шийдэл | Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны                              |                         |
|---|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|------------|----------------------------------------|--------------------------------------------------------------------------------|-------------------------|
|   |                                                                                                                                        |            | Нэр                                    | Албан тушаал                                                                   | Овог нэр                |
|   | 1                                                                                                                                      | 2          | 3                                      | 4                                                                              | 5                       |
| 1 | Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 73 нэр төрлийн 223.0 сая төгрөгийн хөрөнгийн асуудлыг холбогдох эрх бүхий байгууллагаар шийдвэрлүүлэх. |            | Зөвлөмж                                | Ажлын албаны даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Ерөнхий нягтлан бодогч | Ц.Амартөгс, Н.Болортуяа |
| 2 | ТЕЗ нь дотоод аудитгүй бөгөөд тайлант онд санхүүгийн болон бусад үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалт хийгдээгүй байна.               |            | Зөвлөмж                                | Ажлын албаны даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Ерөнхий нягтлан бодогч | Ц.Амартөгс, Н.Болортуяа |

## This image shows a full page of a handwriting practice worksheet. It consists of approximately 20 horizontal rows. Each row is defined by two parallel dotted lines, creating a series of uniform gaps for writing. The lines are evenly spaced across the entire page, providing a guide for letter height and placement. There is no text or other markings on the page.

[illegible]

[illegible]